



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.05.28 № 51-1/85
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244002261



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.05.27 № ХЭГ/1055
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 3 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245008469



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.05.24 № 01/4218

танай 2024.05.21-ны № 01/4507-Т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА ТАНАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001547



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.05.24 № 1/2750
танай 2024.05.24-ны № 01/0508т

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА
ТАНАА**

Танаас ирүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

151603338
Доулам а52024

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлд:

“19.ХЭЛЭЛЦСЭН нь: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ
ХУУЛЬ/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА-ИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.” гэж, 22 дугаар зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмийн хангамж эдлэх, түүнчлэн нэр төрөө хадгалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ улс бүрийн бүтэц, нөөц бололцоотой уялдуулан үндэсний хүч чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны замаар хэрэгжүүлэх эрхтэй.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурал 2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцыг соёрхон баталснаар тус конвенцын үзэл баримтлалд нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дотоодын хууль тогтоомжоо боловсронгуй болгох, холбогдох зохицуулалтыг сайжруулах үүргийг хүлээсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж, Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг дурдаж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” хэмээн баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” хэмээх Хоёрдугаар бүлгийн 2.3.3-т “...хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтыг сайжруулна.” гэж, 2.6.14-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог

дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.” гэж, 2.6.16-д “...хөгжлийн бэрхшээлтэй иргэд хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.” гэж, “Амьдралын чанар ба дундаж давхарга” хэмээх бүлгийн 3.1.18-д “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, “Амар тайван, аюулгүй нийгэм” хэмээх Долоодугаар бүлгийн 7.3.5-д “Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-д хоригдож хүмүүжиж байгаа суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүний эрхийг дээдэлсэн орчин нөхцөл бүрдүүлнэ.” гэж, 7.3.11-д “Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл зөвлөгөө өгөх төвийг байгуулна.” гэж тус тус тусгасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Хоёрдугаар бүлгийн 2.5.8-д “Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.”, 2.5.13-т “Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх боломжоор хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”, Дөрөвдүгээр бүлгийн 4.3.3-т “Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 2021 оны 12 дугаар тогтоолд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан болно.

1.2. Практик шаардлага

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зүйн харилцааг 1995 онд Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулийг баталсанаас хойш 2005 онд шинэчлэн найруулж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байгаад 2016 онд үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлт бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулж байна. Тус хуульд 7 удаа буюу 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “их дээд сургуульд сургуульд суралцах шалгалтанд тэнцсэн хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцах”, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “Ерөнхий боловсролын болон тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардлыг санхүүжүүлэх, үдийн хоолоор үйлчлэх журмыг батлахтай холбоотой болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвд нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих”, 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр “...үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө гэснийг бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “...нийслэл, сум гэснийг сум, нийслэл” гэж өөрчлөх, 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр 11.3 дахь хэсэгт “...төрийн захиргааны гэсний дараа төв” гэж нэмсэн бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн

даатгалын тухай ерөнхий хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тус хууль хэрэгжиж эхэлснээс 5 жилийн дараа хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, талууд нэгдмэл ойлголтод хүрээгүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавхи сул, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр хуулийн зохицуулалтын давхардал 24.4 хувь, зөрчил 35.5 хувь, хийдэл 13.3 хувь байна. Давхардлын 61 орчим хувь нь нийгмийн халамжийн, 34 орчим хувь нь боловсролын үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд байна.

Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд үндсэн эрхийг баталгаажуулж, түүнийг хамгаалах, эрхийг хангах хугацаа, дараалал зэрэг нарийвчилсан зохицуулалтыг салбарын бусад хуультай уялдуулж, тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль зэрэг холбогдох хуульд нийцүүлэх байдлаар дээрх давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, тогтоомжийн уялдаагүй байдал, тэднийг хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг хангалттай бүрдүүлээгүйгээс хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80 орчим хувь нь ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй, үүний улмаас ядууралд өртөж байна. Мөн байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүнийг асран халамжлагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлагатай байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртөө тохирох ажлын байр бий болгосон бол түүнийг нь "тохируулгатай ажлын байр" гэж тодорхойлон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл олгож, дэмжих нь нэг талаас түүний орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас тухайн хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх боломж бий болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 56 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бүрэн эрх, чиг үүргийг хуульд нарийвчлан зохицуулаагүйгээс бусад салбарын төрийн захиргааны байгууллагатай чиг үүргийн давхардал үүсэж байна.

Хуулийн зарим нэр томъёог НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зорилго, агуулгад нийцүүлэх шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооны 2022 оны жилийн эцсийн мэдээгээр Монгол Улсад 115.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь нийт хүн амын 3.3 хувийг эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүсгэн байгуулсан, эсхүл тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй 900

гаруй төрийн бус байгууллага байна. Эдгээр байгууллагын дийлэнх нь төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх хүсэлт тогтмол ирүүлдэг бөгөөд тэдгээрт тавигдах шаардлага тодорхойгүйгээс нэг талаас гэрээ байгуулахад хүндрэлтэй, нөгөө талаас ажлын гүйцэтгэлийн чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангах, хөгжлийн бэрхшээл судлалыг хөгжүүлэх, бие даан амьдрах үйлчилгээг бэхжүүлэх, гадаадын их, дээд сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутан залууст дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд зуучлах карьер экспо зохион байгуулах зэрэг салбар дундын болон төсвийн уялдаагүй байдлаас тэдний эрх бодитоор хэрэгжих болон бусад олон асуудлыг шийдвэрлэх боломжгүй болгож байна.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн хомсдол бий болсон бөгөөд салбарт ажиллагсдыг тогтвортой ажиллуулах асуудлыг нийгмийн баталгааны дэмжлэгтэй уялдуулах зайлшгүй хэрэгцээ бий болсон байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургаж, мэргэжил эзэмшүүлснээр хөгжлийн бэрхшээлийн салбарт бий болсон хүний нөөцийн хомсдолыг бууруулах боломж бүрдэх юм.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломж нөхцөл хомс, тэдгээрийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бие даан амьдрах эрхийг хангах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ бүрийг тодорхой болгох, шаардлагатай зарим үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, эдгээр үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох шаардлагатай.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын үндэслэн хуулийн бүтэц, уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулна.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хамгаалах талаар баримтлах зарчим, иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагын эрх, үүрэг, оролцоог зохицуулахад оршино.

Хуулийн төсөл нь нийт 12 бүлэг, 46 зүйлтэй байх бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: хуулийн зорилтыг тодорхойлж, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, одоогийн хууль тогтоомжид заасан зарим нэр томъёог Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэн өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим зэрэг харилцааг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах, хөгжлийн

бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллах, амьдрах орчин нөхцлийг сайжруулах арга хэмжээг тодорхойлно.

Гуравдугаар бүлэгт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл, Монгол дохионы хэл, үүнтэй холбоотой тодорхойлолт, чиг үүрэг, хамаарах төрийн байгууллагын үүргийг тодорхой болгох, брайль үсгийн стандарт, хөгжлийн бэрхшээлийн салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх зэрэг зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг төрөөс дэмжих, ажлын байрны сонгон шалгаруулалтын харилцааг зохицуулна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон нарийвчилсан зохицуулалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах болно.

Тавдугаар бүлэгт: Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, туслах бүтээгдэхүүний асуудлыг тусгасан бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээ болон туслах бүтээгдэхүүний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.

Зургадугаар бүлэгт: Олон нийтэд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ, олон нийтэд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ эрхлэхтэй холбоотой асуудлыг зохицуулна.

Долоодугаар бүлэгт: хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хамгаалал хүртэх эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангагдахад, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн жишиг үнийг тогтоох, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохтой холбоотой асуудлыг зохицуулна.

Наймдугаар бүлэгт: хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх, хувийн нууцыг хүндэтгэх, бие даан амьдрах эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний спортын үйл ажиллагааг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих, онцгой байдлын үед авах арга хэмжээг нарийвчлан зохицуулна. Цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах, өмгөөллийн үйл ажиллагааг хүртээмжтэй авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлт цуцлахад хүүхдийн тэтгэлгийг хангалттай хэмжээнд тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн стандарт батлах, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх, хөтөч нохой сургахтай хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхтэй холбоотой дэмжих үйлчилгээнүүдийг бий болгон үүнтэй холбоотой зардлын асуудлыг шийдвэрлэх, спорт болон урлаг соёлын үйл ажиллагааг дэмжих, хүртээмжтэй орчин нөхцөлөөр хангах, оролцогч, тамирчдыг урамшуулах хөрөнгийн эх үүсвэрийг давхардуулахгүй байх, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн Эрүүл мэндийн даатгалыг холбогдох хуулиудад заасны дагуу төрөөс хариуцахаар асуудлыг зохицуулна.

Есдүгээр бүлэг: Засгийн газрын үүрэг, асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үндэсний хороо, засаг даргын бүрэн эрх, хуулийн этгээдийн нийтлэг эрх үүрэг, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, нийтлэг эрх, үүрэг гэсэн харилцааг зохицуулна

Аравдугаар бүлэгт: Засгийн газрын үүрэг, асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үндэсний хороо, засаг даргын бүрэн эрх, хуулийн этгээдийн нийтлэг эрх үүрэг, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, нийтлэг эрх, үүрэг гэсэн харилцааг нарийвчлан зохицуулна.

Арваннэгдүгээр бүлэгт: Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3-д заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сан болгон өөрчлөх зохицуулалтыг шинээр нэмнэ.

Арванхоёрдугаар бүлэгт: хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилтийг хянах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилчдын нийгмийн баталгаа, гомдол, нэхэмжлэл гаргах, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хуулийг даган мөрдөх журмын зохицуулалт, хууль хүчин төгөлдөр болох харилцааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар гарна:

Хуулийн зохицуулалт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцэж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нийгмийн бүх салбарт бодитой хангах нөхцөл бүрдэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, боловсролд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, эдийн засгийн байдал сайжирна;

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүсгэн байгуулсан, эсхүл тэдний эрхийг хамгаалахаар нэгдсэн төрийн бус байгууллагуудын шалгуурыг тодорхойлсноор төр иргэний нийгмийн түншлэл бэхжиж, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирна;

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлж, салбар нэгжтэй болсноор байгууллагын чадавх бэхжиж, салбар дундын уялдаа холбоо сайжирна;

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг дэмжих санхүүжилтийн тогтолцоо тодорхой болж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг/-ийн нийгмийн хамгаалал сайжирна.

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэнд, хүртээмжийн зохицуулалтыг холбогдох салбарын бусад хуульд нийцүүлнэ.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдуулсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Монгол хэлний тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

___оОо___

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар 2009 онд НҮБ-ын Монгол Улсын Их хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын тухай хуулийг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болгон шинэчлэн баталсан билээ.

Энэ хууль батлагдсанаар хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох, нийгмийн харилцаанд бусдын адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулах зэрэг чиглэлээр зарим ахиц дэвшил гарсан.

Гэвч 4 жилийн дараа тус хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн зарим зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавхи сул байна. Түүнчлэн хуулийн давхардал, хийдэгдэл, хууль хоорондын зөрчил их байна гэсэн гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. тодруулбал, хуулийн нийт зохицуулалтын 24,4 хувь нь давхардсан, 35,5 хувь нь тодорхой хэмжээгээр бусад хуультай зөрчилдсөн шинжтэй байна.

Эдгээр давхардал, хийдэгдэл, зөрчлийг арилгах, НҮБ-ын конвенц болон НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжид нийцүүлэхэд хуулийн 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байсан учир Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд шинээр 4 зүйл нэмэгдсэн болно.

Хуульд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүх шатны боловсрол эзэмших, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн зэрэг үйлчилгээнд хамрагдахад тулгамдаж байсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор зарим шинэ төрлийн зохицуулалтыг нэмлээ.
- Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад хүний нөөцийн хомсдол бий болсон бөгөөд мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэхээс гадна одоо энэ салбарт ажиллаж байгаа мэргэшсэн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг нийгмийн баталгааны дэмжлэгтэй уялдуулах зайлшгүй хэрэгцээ бий болсон байна. Иймд энэ асуудлыг хуулийн төсөлд шинээр орууллаа.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн үзүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг дэмжих, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох шинэ арга зүйг нэвтрүүлэх зэрэг асуудлыг тусгалаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг чадавхижуулах, магадлан итгэмжлэх замаар мэргэшсэн чиглэлээр төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллахыг дэмжих зэрэг шинэлэг зохицуулалтыг тусгаад байна.

Хуулийн давхцал, хийдэгдэл, зөрчлийг арилгах зорилгоор нийт 20 гаруй хуульд нэмэлт, нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслөөр төр, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан нийт 20 гаруй удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 460 гаруй санал гарсныг тусгасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийг хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхээс гадна дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн саналд үндэслэн боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ” ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар 2009 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр энэхүү конвенцын үзэл баримтлалд нийцсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулсан билээ.

Дээрх хууль шинээр батлагдсанаар өмнө нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүний төрийн тусламж, дэмжлэг болон эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэх харилцааг голчлон зохицуулж байсныг өөрчилж, хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох, нийгмийн харилцаанд бусдын адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг бүрдүүлж, хүний эрхэд чиглэсэн зохицуулалтыг үндэс суурь болгосон.

Тус хууль хэрэгжиж эхэлснээс 4 жилийн дараа хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн зохицуулалт зорилгодоо хүрч чадаагүй, талууд нэгдмэл ойлголтод хүрээгүй, хуулийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаагүйгээс төсөв хөрөнгө дутагдалтай, хүний нөөц, чадавхи сул, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Тодруулбал, хуулийг хэрэгжүүлэх механизм сул, төрийн байгууллагуудын үүрэг зарим талаар хэт ерөнхий, мөн энэ салбарт ажиллагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн хамгааллын зохицуулалт дутмаг, төрийн бус байгууллагуудын эрх, үүрэг тодорхойгүй, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад хуулиар дэмжлэгийг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр байхгүй, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй зэрэг зохицуулалтыг тодорхой болгох асуудал, хэрэгцээ шаардлагаас үүдэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах практик шаардлагатай тулгараад байна.

Хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг тогтоосон байдлаас үзэхэд давхардал 24,4 хувь, зөрчил 35,5 хувь, хийдэл 13,3 хувийг тус тус эзэлж байна. Давхардлаас үзэхэд нийт давхардлын 61 орчим хувь нь нийгмийн халамжтай, 34 орчим хувь нь боловсролтой холбоотой, 5 орчим хувь нь бусад салбарын хууль тогтоомжтой холбоотой байна. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд үндсэн эрхийг баталгаажуулж, түүнийг хамгаалах, эрхийн хангах хугацаа, дараалал, хариуцах этгээд зэрэг процедурыг бусад салбар хуулиар, тухайлбал Нийгмийн халамжийн тухай хууль болон Боловсролын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар зохицуулах хэрэгтэй байна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах эрхийг баталгаажуулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Дэмжих үйлчилгээ”-ний хэлбэрүүд, тэдний үүсгэн байгуулсан, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг төрийн бус байгууллагаар хуульд төрийн заасан чиг үүргийг гэрээгээр

гүйцэтгүүлэх үйл явц, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бүрэн эрх, чиг үүргийг илүү тодорхой болгож, аймаг, дүүрэгт салбартай болгох, хуулийн зарим нэр томъёог Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх зэрэг үндэслэл, практик шаардлагыг харгалзан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсруулна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулах бөгөөд зарчмын шинжтэй дараах асуудлыг нэмж тусгана. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон байраар хангах, хөгжлийн бэрхшээл судлалыг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр гадаадын болоод дотоод чуулга уулзалт, эрдэм шинжилгээний хурал, уулзалт зохион байгуулах, таатай орчин нөхцөл бүрдүүлэх, бие даан амьдрах үйлчилгээг бэхжүүлэх, гадаадын их, дээд сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй оюутан залууст дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сан байгуулах юм. Сангийн хөрөнгийн эх үүсвэр нь Засгийн газрын тусгай сангийн хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хууль тогтоомж зөрчигчдөд холбогдох хуулийн дагуу хүлээлгэсэн хариуцлагын торгуулийн мөнгө болон бусад эх үүсвэрээс бүрдэхээр тусгана.

- Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн хомсдол бий болсон бөгөөд салбарт ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг нийгмийн баталгааны дэмжлэгтэй уялдуулах зайлшгүй хэрэгцээ бий болсон байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургаж, мэргэжил эзэмшүүлснээр хөгжлийн бэрхшээлийн салбарт бий болсон хүний нөөцийн хомсдолыг бууруулах боломж бүрдэнэ.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд төрөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь үзүүлэх боломж нөхцөл хомс байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх, үүнд шаардлагатай санхүүжилтийг аймаг, орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тусгана.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага болон хууль зөрчигчдийг хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтад хамруулна гэж заасан байдаг ч ямар сургалтыг хэн зохион байгуулах, цаашлаад уг сургалтын журам боловсруулах асуудлыг нарийвчлан тусгана.

Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүнд хүрнэ:

- 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нийгмийн бүх салбарт бодитой хангах нөхцөл бүрдэх бөгөөд ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн байдал сайжирна;

- 2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна;

3.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүсгэн байгуулсан, эсхүл тэдний эрхийг хамгаалахаар нэгдсэн төрийн бус байгууллагуудын шалгуурыг тодорхойлсноор төр иргэний нийгмийн түншлэл бэхжиж, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирна;

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлсноор байгууллагын чадавх бэхжиж, салбар дундын уялдаа холбоо сайжирна;

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг дэмжих, үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтолцоо тодорхой болж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг/-ийн нийгмийн хамгаалал сайжирна.

6.Хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд олгох урамшууллын төсвийн эх үүсвэр тодорхой болж, төсвийн эх үүсвэр давхардахгүй болно.

7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрны дэмжлэгийн зохицуулалт тодорхой болсноор үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.

8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг Үндэний хороо болгон өөрчилж, хорооны ажиллах хэлбэр, ажлын албаны чиг үүрэг тодорхой болно.

9.Хуулийн давхардал, хийдэл арилж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэнд, хүртээмжийн зохицуулалт нь салбарын бусад хуулиар нарийвчлан зохицуулагдана.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Хуулийн III бүлэг буюу хүртээмжтэй орчин нөхцөлийн 8-12 дугаар зүйл нь Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөлд тусгагдах бөгөөд үндсэн асуудлаар шинээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сантай холбоотой 1 бүлэг, Улсын Их хурлын эрх, үүрэг, хүний нөөц бэлтгэх, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, салбарын нийгмийн хамгааллын асуудлаар 4 зүйл нэмэгдэж, хуулийн 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Биеийн тамир, спортыг дэмжих тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад шаардлагатай 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хамгаалах талаар баримтлах зарчим, иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагын эрх, үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагад нэгэн адил хамаарна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны болон хандлагын бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох боломж нь хязгаарлагдсан хүүхэд, насанд хүрэгчийг;

4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, шаардлагатай тохируулгаар хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. "туслах бүтээгдэхүүн" гэж хувь хүний үйлдэл, бие даасан байдлыг сайжруулах, эсхүл хэвийн хэмжээнд нь хүргэх зориулалттай хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл, тоног төхөөрөмж, харилцаа холбоо, мэдээлэл технологийн хэрэгсэл зэрэг бүх төрлийн бүтээгдэхүүнийг;

4.1.4. "шаардлагатай тохируулга" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.5. "туслах технологи" гэж туслах бүтээгдэхүүн, шаардлагатай тохируулга, түүний үйлчилгээг хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг;

4.1.6. "түгээмэл загвар" гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ хангамж, орчин болон үйлчилгээний хэв маяг, архитекторын шийдлийг;

4.1.7. "олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.8. "бие даан амьдрах эрх" гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;

4.1.9. "хөтөч нохой" гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.10. "Дохионы хэлний хэлмэрч, орчуулагч" гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд ярианы хэлнээс дохионы хэл рүү, дохионы хэлнээс ярианы хэл рүү, дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг хүнийг;

Тайлбар: "Дохионы хэлний хэлмэрч" гэж ярианы хэлнээс дохионы хэл рүү, дохионы хэлнээс ярианы хэл рүү хэлмэрчилдэг бүрэн сонсголттой хүнийг; "Дохионы хэлний орчуулагч" гэж дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн орчуулдаг хүнийг; "Дохионы хэлний тактиль хэлмэрч" гэж хараа, сонсголын хавсарсан бэрхшээлтэй хүнд ярианы хэл болон дохионы хэлнээс дохионы хэл рүү хөрвүүлэн хэлмэрчилдэг хүнийг хэлнэ.

4.1.11. "Ажлын байрны дадлагажуулагч" гэж ажлын байран дээр аж ахуйн нэгж, байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, энэ чиглэлийн арга зүйг эзэмшсэн хүнийг".

5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим

5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах бодлого, үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжих эрхийг хангах, сонголт хийх эрх, онцлог, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, хөдөлмөрлөх зэрэг нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхийг хангахад саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ

6 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй.

6.2.Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагын дараах үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1.барилга байгууламж, авто зам, замын байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр саадгүй хүртээмжтэй зорчих орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тэгш хамран суралцахад шаардагдах тохируулгат орчин, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах аливаа үйлдэл, үл хайхралт, дарамт, шахалт үзүүлэх;

6.3.4.хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;

6.3.6.төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх;

6.3.7.сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлээгүй байх.

6.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагын дараах үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1.ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах, зайлсхийх;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь ажилтныг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон шаардлагатай тохируулга бүхий ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.5.Дараах үйлдлийг гэр бүл болон олон нийтийн орчин дахь ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах;

6.5.2.олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх;

6.5.3.хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.4.гэр бүлийн гишүүн, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух, түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадавхжуулах үйлчилгээнд хамруулахаас татгалзах, зайлсхийх;

6.5.5.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг хуульд зааснаас бусад үндэслэлээр үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах;

6.5.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх болон хуульд заасан бусад эрхийг хязгаарлах;

6.5.7.хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар гэр бүлтэй болох, гэрлэхийг хориглох, эсэргүүцэх, өв хөрөнгийг өвлөх эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн, үр ашигтай оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг шаардлагатай тохируулгаар хангах, саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах, онцлогт нь тохируулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

7 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээ

7.1.Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх, түүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагыг хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад 3 жил тутамд хамруулна;

7.1.2.иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулна;

7.1.3.хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэг ойлголтыг түгээх, төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн хөтөлбөрийг олон нийтийн радио, телевиз үнэ төлбөргүй, бусад хэвлэл мэдээллийн байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд нийтийн хүртээл болгоно;

7.1.4.иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага, гэр бүл, хамт олны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хүний эрхийг дээдэлсэн нийгмийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн санал санаачлагыг дэмжих, үүнтэй холбогдох зардлыг хүүхэд, залуучуудын хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэх;

7.2.Энэ хуулийн 7.1.1-д заасан сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх, төлбөрийн хэмжээг зохицуулах журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.3.Энэ хуулийн 7.1-д заасан зарим арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, байгууллагаар гүйцэтгүүлж болно.

8 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах

8.1.Барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй байна.

8.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллах, амьдрах орчин нөхцөл, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээг сайжруулахтай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

9 дүгээр зүйл.Сурч боловсрох эрх

9.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхийг хангах чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.1.1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.3-т заасан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, сурагчдад гарсан ахиц, өөрчлөлтийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх удирдлага эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой хэлэлцэж, дүгнэлтийг тухайн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон энэ хуулийн 32.2.1-д заасан зөвлөлд хүргүүлэх.

9.2.Боловсролын ерөнхий хуулийн 11.6-д заасан үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах идэвх, санаачилгыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, түүний онцлог хэрэгцээнд нийцүүлэн брайль үсэг, монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон арга зүй, харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох, зөвлөн туслахад чиглэсэн дэмжлэг үзүүлэх ба холбогдох журмыг боловсролын, эрүүл мэндийн, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

10 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох нөхцөл

10.1.Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид амьдрах ухаан, ур чадварыг үр дүнтэй эзэмшүүлэх бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10.1.1.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд зааснаас гадна тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн дэмжигч, явуулын болон багшийн туслахын дэмжлэгтэйгээр боловсрол эзэмшүүлж, цаашид дэвшин суралцахад туслалцаа үзүүлэх;

10.1.2.элсэлтийн шалгалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн шаардлагатай тохируулгаар хангаж, хүртээмжтэй орчин, нөхцөлд зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг олгох.

10.2.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.

10.3.Хөдөлмөрийн зах зээлд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр хомсдолтой байгаа мэргэжлээр элсэлтийн шалгалтад тэнцэж дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлнэ.

10.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох үйл ажиллагааг дагнан явуулж байгаа сургалтын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ба жишиг зардлыг тооцох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11 дүгээр зүйл.Монгол дохионы хэл

11.1.Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний албан ёсны эх хэл мөн.

11.2.Сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

11.3.Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь монгол дохионы хэлээр харилцах нөхцөлийг бүрдүүлж, дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйлчилгээгээр хангана.

11.4.Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулагч бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх, ашгийг хамгаалдаг болон тэдэнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын саналыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.5.Дохионы хэлмэрч, орчуулагч бэлтгэх ажлыг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх, ашгийг хамгаалдаг болон тэдэнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

11.6.Монгол дохионы хэлийг эзэмшүүлэх, сургах, судлах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, түүний хэрэгжилтийг хангах чиг үүргийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл хэрэгжүүлнэ.

11.7.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд Дохионы хэлний хөгжлийн орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл батална.

11.8.Сонсголгүй хүнд монгол дохионы хэл болон бичгийн монгол хэлний хосолсон хөтөлбөрөөр бүх шатны боловсрол эзэмшүүлнэ.

11.9.Энэ хуулийн 11.8-д заасан хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан хэрэгжүүлнэ.

11.10. Сонсголын бэрхшээлтэй үндэсний цөөнх иргэд өөрийн соёл, уламжлал, хэлний онцлог бүхий дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

12 дугаар зүйл.Брайль үсгийн стандарт

12.1.Харааны бэрхшээлтэй хүн брайль бичгийг ашиглан боловсрол эзэмших эрхтэй бөгөөд бүх түвшний боловсролын сургалтын байгууллага харааны бэрхшээлтэй хүн брайль бичиг болон бусад технологи ашиглан боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

12.2.Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан байгууллага батална.

13 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх

13.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жил тутамд батална.

13.2.Эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн болон барилга байгууламж, авто зам, замын байгууламж, мэдээллийн технологи, харилцаа холбоо, хүний нөөцийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн ерөнхий суурь хэсгийн сургалтын хөтөлбөр, агуулгад хөгжлийн бэрхшээлийн тухай мэдлэг ойлголт олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах агуулга, арга зүйг тусгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

14 дүгээр зүйл.Хөдөлмөрлөх эрх

14.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй.

14.2.Иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн шаардлагатай тохируулга бүхий ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1-д заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй.

14.3.Өмчийн бүх хэлбэрийн 100 болон түүнээс дээш ажилтантай байгууллага нь дэмжлэг шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангасан тохиолдолд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу ажлын байрны дадлагажуулагч ажиллуулж болно.

14.4.Иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахдаа энэ хуулийн 6.4-т заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

14.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

15.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтэд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ:

15.1.1.өөртөө ажлын байр бий болгосон хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3-т заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

15.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний дунд мэргэжлийн ур чадварын тэмцээнийг дотоодод зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

15.1.3.мэргэжлийн ур чадварын бүс, тив, дэлхийн тэмцээнд оролцох эрх авсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3-т заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас дэмжлэг үзүүлэх;

15.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэлж байгаа бизнес, тэдний үүсгэл, санаачилгаар байгуулагдсан аж ахуйн нэгжийг санхүүгийн болон хууль тогтоомжид заасан бусад нөхцөлөөр дэмжих;

15.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын орлого олох, ажлын байраар хангагдахад нь тусгайлан дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулах;

15.1.6.мэргэжил эзэмшиж ажлын байран дээр гарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байрны шаардлагатай тохируулга хийх, тоног төхөөрөмжөөр хангахад нэг удаагийн дэмжлэгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3-т заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас үзүүлэх.

15.2.Энэ хуулийн 15.1.3-т заасан тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.3.Ажлын байрны тохируулга хийх, ажлын байрны тохируулгыг үнэлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

16 дугаар зүйл.Ажлын байрны сонгон шалгаруулалт

16.1.Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарлахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээг харгалзан үзнэ.

16.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүн нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо түүний хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн шаардлагатай тохируулгаар хангагдах, нэмэлт цаг ашиглах эрхтэй.

16.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ зүйлийн 16.2-т заасан хэрэгцээ, шаардлагын талаар хүсэлт гаргасан тохиолдолд сонгон шалгаруулалт явуулж байгаа байгууллага хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

17 дугаар зүйл.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

17.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах чиглэлээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

17.1.1.эрүүл мэндийг дэмжих, хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах, хөнгөвчлөх, туслах бүтээгдэхүүнээр хангах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

17.1.2.бүх шатны эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх;

17.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хангахад чиглэсэн хүний эрхэд суурилсан олон улсын жишигт нийцсэн үйлчилгээ нэвтрүүлж, эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх;

17.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх;

17.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хүний нөөцийн судалгааг гаргаж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх;

17.1.6.хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж, хяналт тавих.

17.2.Энэ зүйлийн 17.1.2-т заасан тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, эм, урвалж бодис, эрт илрүүлгийн хэрэгсэл, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

17.3.Энэ зүйлийн 17.1.3-т заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

17.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

18 дугаар зүйл.Туслах технологи

18.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, бие махбодийн онцлог, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогт нь тохирсон, чанар, стандартын шаардлага хангасан туслах бүтээгдэхүүнээр хангагдах эрхтэй.

18.2.Туслах бүтээгдэхүүн авах зардлыг холбогдох хуульд заасны дагуу Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангаас тус тус санхүүжүүлнэ.

18.3.Энэ хуулийн 32.2.4-т заасан салбар зөвлөл нь 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээнд нийцсэн туслах бүтээгдэхүүн олгох шийдвэр гаргана.

18.4.Туслах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН ХАМРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ

19 дүгээр зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ

19.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

19.1.1.өвчин, эмгэг, гэмтэл, бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн эрүүл мэндийн;

19.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил боловсрол, мэргэжил эзэмшихийг дэмжих боловсролын;

19.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүн гэр бүл, хамт олондоо эдийн засгийн хувьд хувь нэмрээ оруулахыг дэмжих хөдөлмөрийн;

19.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн, гэр бүл, хамт олны дунд бусдын адил үүрэг хариуцлага хүлээсэн, идэвхитэй, бие даасан гишүүн болохыг дэмжих нийгмийн;

19.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд оролцохыг дэмжих барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээний хүртээмжийн.

19.2.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн хүний онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

19.3.Энэ зүйлийн 19.1-д заасан үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

20 дугаар зүйл.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ эрхлэх

20.1.Энэ хуулийн 19.1-д заасан үйлчилгээг өмчийн бүх хэлбэрийн байгууллага үзүүлнэ.

20.2.Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тохиолдолд зардлыг бүрэн болон хэсэгчлэн тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

20.3.Энэ хуулийн 19.1-д заасан үйлчилгээний удирдамжийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

20.4.Энэ зүйлийн 20.2-т заасан төрийн бус байгууллага магадлан итгэмжлэх журмыг үзүүлж буй үйлчилгээний чиглэлийн хүрээнд тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нь хүүхдийг энэ хуулийн 32.8-д заасан дүгнэлтийн дагуу хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээнд хамруулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАЛАМЖ

21 дүгээр зүйл.Нийгмийн хамгаалал хүртэх эрх

21.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжид хамрагдахаас гадна хоол хүнс, хувцас, орон байр, нийгэм, ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг авах, өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй.

21.2.Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь шаардлагатай дэмжих үйлчилгээ авах эрхтэй.

21.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хамруулах, орон сууц, хүртээмжтэй орон байраар хангах чиглэлээр барилга, хот байгуулалтын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.3.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууц, орон байрны хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймаг, нийслэлийн Засаг даргын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсөвт тусгах;

21.3.2.гэр хороололд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдарч байгаа орон байрыг инженерийн дэд бүтэц болон тохируулгаар хангах зорилгоор нэг удаагийн дэмжлэг үзүүлэх.

21.4.Энэ зүйлийн 21.3.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг Засгийн газар батална.

21.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэврээс бусад арга хэмжээнд үргэлжлүүлэн хамрагдана.

21.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээ, нийгмийн даатгалд хамруулах асуудлыг Нийгмийн халамжийн тухай хууль, Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

22 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамжийн зарим арга хэмжээ

22.1.Энэ хуулийн 4.1.1-д заасан хүнд Нийгмийн халамжийн сангаас доор дурдсан тусламж, хөнгөлөлтийг үзүүлнэ:

22.1.1.байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хараа, хэл яриа, сонсголын бүрэн чадваргүй, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн түрээсийн орон сууцны төлбөрийн зөрүү төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

22.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эх /эцэг/, эсхүл хууль ёсны асран хамгаалагчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн суралцахуйн төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдахад ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

22.1.3.орон нутгаас албан боловсрол эзэмших зорилгоор аймаг, нийслэлд ирж сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эх /эцэг/, эсхүл хууль ёсны асран хамгаалагчид ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нийтийн тээврийн болон агаарын тээврийн тарифаар тооцон олгох;

22.1.4.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан, сувилалд дараалал харгалзахгүйгээр сувилуулах;

22.1.5.нийслэлээс 500 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын зөвлөлийн шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, нарийн мэргэжлийн шинжилгээ хийлгэх тохиолдолд хот хоорондын зорчигч тээврийн жишиг үнийг үндэслэн тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнд унааны зардлыг жилд нэг удаа 100 хувь, хууль ёсны асран хамгаалагчид 50 хувийг нөхөн олгох;

22.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

22.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

22.1.8.хараагүй хүний брайль үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл зэрэг 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

22.1.9.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хүүхдийн зуслан, харгалзан дэмжигчийн хамт эх, хүүхдийн амралтад амарвал жишиг үнийг харгалзан хүүхдийн эрхийн бичгийн төлбөрийг 100 хувиар, харгалзан дэмжигчийн төлбөрийг 50 хувиар жилд нэг удаа олгох;

22.1.10.хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийн дотоод, гадаадад хийлгэсэн болон худалдан авсан туслах бүтээгдэхүүний үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр жишиг үнийг баримтлан нөхөн олгох;

22.1.11.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14.1.11-д заасан туслах бүтээгдэхүүн хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн туслах бүтээгдэхүүний үнийг гурван жил тутамд нэг удаа жишиг үнийг баримтлан олгоно;

22.1.12.паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний тусламжийг амжилт гаргасан 4 жилийн хугацаанд нэг удаа олгох;

22.1.13.хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхэд, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хиймэл эрхтэн хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан туслах бүтээгдэхүүний үнийг гурван жил тутам нэг удаа жишиг үнийг баримтлан нөхөн олгох;

22.1.14.насанд хүрсэн хараа, хэл яриа, сонсголын бүрэн чадваргүй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх.

22.2.Энэ зүйлийн 22.1-д заасан хөнгөлөлт, тусламжийн жагсаалт, жишиг үнэ, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

22.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино.

22.4.Энэ зүйлийн 22.3-т заасан харилцааг зохицуулах журмыг Засгийн газар баталж, шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, Нийслэлийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

22.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал нийгмийн даатгалын сангаас нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгоно.

22.6.Энэ хуулийн 4.1.1-д заасан хүнд Эрүүл мэндийн даатгалын сангаас доор дурдсан үйлчилгээг үзүүлнэ:

22.6.1. магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан болон сувилалд сувилуулахад;

22.6.1.а. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зардлыг бүрэн;

22.6.1.б. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг асран халамжилж буй нэг иргэний зардлын 50 хувь;

22.6.1.в. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний зардлын 50 хувь.

22.6.2. асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материал;

22.6.3. холголт, цооролтын үеийн эмчилгээний зардал.

22.7. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний байнгын асаргааны зэргийг хамааруулан Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу тогтооно.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ БУСАД ЭРХ

23 дугаар зүйл. Хууль зүйн туслалцаа авах эрх

23.1. Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй байна.

23.2. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, өмгөөлөл, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

23.3. Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүнд түүний эрх, үүрэг болон холбогдох мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт нь нийцүүлэн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр тайлбарлаж өгнө.

23.4.Шүүх, прокурор, цагдаа, өмгөөлөл, хууль сахиулах байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн эрх ашгаа хамгаалахад хүртээмжтэй орчныг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд үйлчилгээ үзүүлэхдээ текст уншигч, бичигч, дохионы хэлний хэлмэрч, орчуулагчаар үнэ төлбөргүй хангана.

23.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хууль зүйн анхан шатны мэдээлэл зөвлөгөөг түүний бэрхшээлийн онцлогт тохируулан хүртээмжтэй хүргэж, чадавхжуулах үйл ажиллагааг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагын эрх зүйн хөтөөр дамжуулан хүргэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

23.6.Энэ зүйлийн 23.1-23.5-д заасан үйлчилгээний зардлыг шүүх, прокурор, цагдаа, хууль сахиулах байгууллагын тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

23.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль зүйн туслалцаа авахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх

24.1.Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, түүнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн, гэр бүл, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ.

24.2.Төрөөс үзүүлж буй эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үнэ төлбөргүй байна.

24.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх төвийг төрийн бус байгууллагын дэргэд ажиллуулж болно.

24.4.Энэ зүйлийн 24.3-т заасан төвөөр дараах үйлчилгээг үзүүлнэ:

24.4.1.сэргээн засах үйлчилгээ;

24.4.2.боловсрол, хөгжлийн үйлчилгээ;

24.4.3.сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ;

24.4.4.сэргээн засах болон боловсрол, хөгжлийн цогц үйлчилгээ.

24.5.Энэ зүйлийн 24.3-т заасан үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн стандартыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

24.7.Энэ зүйлийн 24.3-т заасан төвийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг аймаг, нийслэл, дүүргийн тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

24.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн үйлчилгээ, үйл ажиллагааны жишиг зардлыг Засгийн газар батална.

24.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох ажлыг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

24.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүл, олон нийтэд суурилсан хамруулан хөгжүүлэх хүрээнд олон улсад туршигдсан хөтөлбөр, үйлчилгээнд хамруулж, холбогдох салбарын бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлнэ.

24.11.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу тэтгэлэг төлнө.

24.12.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах тохиолдолд тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцна.

24.13.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд Боловсролын ерөнхий хуулийн 10.1.11 дэх заалтад заасан эрхтэй.

24.14.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

24.15.Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар байнгын асаргаа шаардлагатай 18 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, эсхүл хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрөл, хүсэлтээр 21 насанд хүртэл нь энэ хуульд заасан боловсролын болон асрамжийн үйлчилгээнд хамруулж болно.

25 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний жендэрийн эрх тэгш байдал

25.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

25.1.1.гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэнд, хууль зүйн, сэтгэл зүйн болон бусад шаардлагатай үйлчилгээг түүний сэтгэл зүй, нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлэн мэргэжлийн түвшинд хүртээмжтэй үзүүлэх;

25.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хүртээмжтэй байх;

25.1.3.энэ зүйлийн 25.1.1-д заасан үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

25.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний жөндөрийн эрх тэгш байдалтай холбогдон энэ хуульд зааснаас бусад харилцааг Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

26 дугаар зүйл.Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрх

26.1.Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

26.2.Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хүртээмжтэй байна.

26.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвшихэд улс төрийн нам, эвсэл холбогдох хуульд заасны дагуу дэмжих үүрэгтэй.

26.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар улс төрийн нам, эвсэл, бие даагч бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

26.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Улсын Их Хурал, бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх доод хязгаарыг холбогдох хуулиар баталгаажуулна.

27 дугаар зүйл.Хувийн нууцыг хүндэтгэх

27.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн нууц болон нэр төр, алдар хүндийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор хамгаална.

27.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлж байгаа аливаа этгээд хөгжлийн бэрхшээлтэй хүний нууцыг задруулахыг хориглоно.

28 дугаар зүйл.Бие даан амьдрах эрх

28.1.18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрах эрхтэй.

28.2.Бие даан амьдрах эрх нь дараах дэмжих үйлчилгээгээр хангагдана:

28.2.1.хувийн туслахын үйлчилгээ;

28.2.2.дэмжих бүлэг буюу харилцан суралцах үйлчилгээ;

28.2.3.сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээ;

28.2.4.бие даан амьдрахад бэлтгэх түр байрлуулах үйлчилгээ;

28.2.5.дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ;

28.2.6.хөтөч нохойн үйлчилгээ.

28.3.Энэ зүйлийн 28.2.1-28.2.5-д заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.4.Энэ зүйлийн 28.2.1-28.2.5-д заасан үйлчилгээний жишиг зардлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

28.5.Энэ зүйлийн 28.2.1-28.2.4-т заасан үйлчилгээний зардлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3-т заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлнэ.

28.6.Энэ зүйлийн 28.2.5-д заасан дэмжих үйлчилгээний төлбөрийг тухайн салбарын үйлчилгээ үзүүлсэн байгууллага нь дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлсэн байгууллага, хувь хүнд төлнө.

28.7.Энэ зүйлийн 28.2.6-д заасан үйлчилгээний журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, хөдөө аж ахуйн, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

28.8.Хөтөч нохой сургахтай холбоотой хөрөнгийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ.

28.9.Дэмжих үйлчилгээний журам бүрт үйлчилгээний төрөл, хэлбэр, жишиг зардал, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах, түүнд тавигдах шаардлагыг тусгана.

28.10.Хөгжлийн бэрхшээлтэй хүн бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг иргэн, хуулийн этгээд үзүүлж болно.

29 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжих

29.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулахдаа Биеийн тамир, спортын тухай хууль болон олон улсын спортын байгууллагын дүрэм, стандартад заасныг баримтална.

29.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахад биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

29.2.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход бүх шатны биеийн тамир, спортын байгууллага шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин нөхцөл бүхий заал талбай, тоног төхөөрөмж, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний тусламж үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэх;

29.2.2.хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний хууль ёсны асран хамгаалагч, хувийн туслахыг паралимп, тусгай олимп, дифлимп, тив, дэлхийн тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран оролцоход нь шаардагдах зардлыг улсын төсөвт тусгах, Биеийн тамир, спортын тухай хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх;

29.2.3.паралимп, дифлимп, тусгай олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний дасгалжуулагчид Биеийн тамир, спортын тухай хууль, тогтоомжид заасан мөнгөн шагнал, урамшуулал олгох;

29.2.4.улсын хэмжээнд зохион байгуулж байгаа хүүхдийн, оюутны, үндэсний спортын наадам, Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу эрх авсан спортын холбооноос зохион байгуулах улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний дасгалжуулагчид Биеийн тамир, спортын тухай хууль, тогтоомжид заасан мөнгөн шагнал, урамшуулал олгох.

29.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

30 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжих

30.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдахад дараах эрхийг эдэлнэ:

30.1.1.авъяас чадвараа хөгжүүлэх;

30.1.2.соёл урлагийн бүтээл туурвих;

30.1.3.уралдаан тэмцээн, арга хэмжээнд оролцох;

30.1.4.соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй авах;

30.1.5.соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх.

30.2.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган шийдвэрлэнэ:

30.2.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг соёл урлагийн бүс, тив, дэлхийн чанартай тэмцээн, уралдаанд оролцоход бүх шатны соёл, урлагийн байгууллага нь шаардлагатай тохируулга, хүртээмжтэй орчин нөхцөл бүхий заал талбай, тоног төхөөрөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх;

30.2.2.бүс, тив, дэлхийн чанартай соёл урлагийн уралдаан, тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Засгийн газраас баталсан журамд заасан урамшууллыг 1.5 дахин нэмэгдүүлэн олгох;

30.2.3.бүх шатны соёл урлагийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн уран бүтээлээ олон нийтэд нийтэд толилуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд байр талбайн түрээсийн төлбөрийн 50 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлэх;

30.2.4.соёл урлагийн бүтээлийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрт хөрвүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

30.2.5.соёл, урлагийн ажил эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай багаж, техник, хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх;

30.2.6.хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;

30.2.7.хөгжлийн бэрхшээлийн талаар сөрөг агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоох.

30.3.Өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагын үзвэр үйлчилгээ нь шаардлагатай тохируулга бүхий хүртээмжтэй байна.

30.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний соёл, урлагийн үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Соёлын тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

31 дүгээр зүйл.Онцгой байдлын үед авах арга хэмжээ

31.1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал, цар тахал зэрэг онцгой байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүний амь нас, эрүүл мэндийг нь хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

31.1.1.онцгой байдлын мэдээллийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэр, хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн хүртээмжтэйгээр хүргэх;

31.1.2.хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх;

31.1.3.энэ хуулийн 28.2.1, 28.2.5-д заасан дэмжих үйлчилгээг байгалийн гамшиг, цар тахлын үеийн хөл хорио, нийтийг хамарсан үймээн самуун, бослого тэмцэл, ажил хаялт, бүх нийтийн амралт, баяр ёслолын өдрүүдээс үл хамааран бүх цаг үе, нөхцөл байдалд тасалдуулахгүй авах боломжоор хангах.

31.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх онцгой байдлын үеийн арга хэмжээтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭСЭХИЙГ ТОГТООХ, БҮРТГЭХ**

32 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох

32.1.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах шалгуураар тогтооно:

32.1.1.эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, ангилал, хугацаа;

32.1.2.үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал.

32.2.Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг дараах зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ тогтооно:

32.2.1.0-18 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зөвлөл;

32.2.2.18 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эрүүл мэндийн магадлалын зөвлөл;

32.2.3.үйлдлийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих шийдвэрийг эмнэлэг хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн магадлалын зөвлөл.

32.3.Энэ зүйлийн 32.2.1-д заасан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд төв, аймаг, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэйгээр ажиллана.

32.4.Энэ хуулийн 32.2.3-д заасан зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасны дагуу ажиллана.

32.5.Энэ зүйлийн 32.3-д заасан зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

32.6.Энэ зүйлийн 32.3-т заасан зөвлөл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучилна.

32.7.Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

32.8.18-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох зааврыг эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

32.7.Зөвлөл өөрийн эрх хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхтэн тогтолцооны бүтцийн алдагдал, хугацаа, ангилал, үйлдлийн чадвар алдалтын хувь, хэмжээг тогтоож, дүгнэлт гаргана.

32.8.Энэ зүйлийн 32.2.1, 32.2.2-т заасан зөвлөлөөс гаргасан дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх болон хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах болон бусад хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт бичиг болно.

33 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэх, тоо мэдээллийг нэгтгэх

33.1.Энэ хуулийн 32.2-т заасан зөвлөл өөрийн дүгнэлтэд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэж, үнэмлэх олгоно.

33.2.Энэ зүйлийн 33.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

33.3.энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т заасан зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоосон хүний статистик мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

33.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 32.2.1, 32.2.2-т заасан зөвлөлөөс ирүүлсэн статистик мэдээллийг нэгтгэн хуулиар тогтоосон хугацаанд статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хүргүүлнэ.

33.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, мэдээллийг нэгтгэсэн "Мэдээллийн нэгдсэн сан"-г хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрдүүлж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

33.6.Энэ зүйлийн 33.5-д заасан "Мэдээллийн нэгдсэн сан"-г бүрдүүлэх статистик мэдээллийн үзүүлэлт, аргачлал, заавар, маягт, загварыг Статистикийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ

34 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

34.1.Улсын Их Хурал хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

34.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

34.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх төсөв батлах;

34.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт, төлөв байдлын талаарх мэдээллийг хоёр жил тутамд хэлэлцэж, шийдвэр гаргаж, Засгийн газарт хүргүүлэх;

34.1.4.хууль тогтоомжийг хөгжлийн бэрхшээлийн мэдрэмжтэй боловсруулсан эсэхэд хяналт тавьж батлах.

34.2.Хууль тогтоомжид зааснаас бусад.

35 дугаар зүйл.Засгийн газрын чиг үүрэг

35.1.Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөр, улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн тусгаж хэрэгжүүлэх;

35.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчдын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн хөрөнгийг хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

35.1.3.Засгийн газрын гишүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан хэлэлцэх;

35.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжилтийг Улсын Их Хуралд тайлагнах.

35.2. Засгийн газрын гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.2.1.санхүүгийн асуудал хариуцсан засгийн газрын гишүүн салбарын онцлогт нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн төсвийн эдийн засгийн ангиллыг Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр үүсгэн батлах;

35.2.2.Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан Стратеги төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлыг заавал тусган хэрэгжүүлэх;

35.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган зарцуулах, олон нийтэд тайлагнах.

36 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

36.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан агентлагийн нийтлэг эрхлэх асуудлаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангахад чиглэсэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний

хороонд болон хөгжийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тайлагнах;

36.1.2.харьяа байгууллагын болон салбар дундын хүний нөөцийг тасралтгүй сургах, мэргэшүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

36.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр бүх шатны Засаг дарга болон бусад салбаруудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

36.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, өмчийн бүх хэлбэрийн байгууллагад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх;

36.1.5.энэ хуульд заасан төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх, гэрээлэн гүйцэтгэж буй төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

36.1.6.хуульд заасан болон холбогдох бусад тоо, статистик, мэдээллээр төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай хангах;

36.1.7.хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

36.1.8.өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргуулахаар эрх бүхий байгууллагад санал боловсруулж, уламжлах;

36.1.9.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх асуудлыг тусгаж, хэрэгжүүлэх;

36.1.10.хөгжлийн бэрхшээлийн салбарт хийгдэж буй судалгаа шинжилгээний нэгдсэн сан үүсгэх, судалгаа шинжилгээний ажлыг бүх талаар дэмжих, олон нийтэд сурталчлах;

36.1.11.хууль тогтоомжид заасан бусад.

37 дугаар зүйл. Үндэсний хороо

37.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хороо /цаашид “Үндэсний хороо” гэх/-г Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулж болно.

37.2.Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

37.3.Үндэсний хороо нь жил бүрийн 3 дугаар сар, 9 дүгээр сард тус бүр ажлын 10-аас доошгүй хоногийн хугацаанд хуралдана.

37.4.Үндэсний хороо нь төрийн захиргааны төв байгууллагад дэд, аймаг, нийслэл, дүүрэгт салбар хороотой байх бөгөөд дэд хороог тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, салбар хороог Засаг дарга тэргүүлнэ.

37.5.Үндэсний хорооны ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, салбар хорооны ажлын албаны үүргийг тухайн орон нутгийн нийгмийн бодлогын асуудал эрхэлсэн нэгж тус тус гүйцэтгэнэ.

37.6.Дэд хороог зарим төрийн захиргааны байгууллагын дэргэд байгуулж болох бөгөөд тухайн байгууллагын дарга тэргүүлнэ.

37.7.Үндэсний хороо нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

37.7.1.салбар дундын бодлого, үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

37.7.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсвийн зарцуулалт болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

37.7.3.дэд, салбар хорооны тайлан, мэдээллийг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

37.7.4.дэд, салбар хорооны гишүүнийг шагнал, урамшилд тодорхойлох;

37.7.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэж Засгийн газарт танилцуулах;

37.7.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх;

37.7.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг дээдлэгч байгууллага, иргэнийг шалгаруулан алдаршуулах журмыг хөгжийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэх;

37.7.8.хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүртээмжийг сайжруулах арга хэмжээг тусган хэрэгжүүлэх ба жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, зөвлөмж гарган хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар хороонд хүргүүлэх.

37.8.Үндэсний хороо ажлаа Засгийн газарт тайлагнана.

38 дугаар зүйл.Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

38.1.Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах талаар харьяалах нутаг дэвсгэртээ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

38.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсөв хуваарилах, зарцуулах, хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

38.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, биеийн тамир, спорт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалт, сурталчилгаа зэрэг шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;

38.1.3.барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй, хүртээмжтэй байх хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

38.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүнд олон нийтэд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

38.1.5.аж ахуйн нэгж, байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй үйлчлэх санал, санаачилгыг дэмжих;

38.1.6.энэ хуулийн 22.3-д заасны дагуу нийтийн тээврийн хэрэгслээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчуулах, нөхөн олговрыг санхүүжүүлэх журмыг хэрэгжүүлэх хөрөнгийг жил бүрийн төсөвтөө тусган батлах;

38.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгуулан батлуулах;

38.1.8.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, түүний хэрэгжилтийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний хороонд тайлагнах;

38.1.9.хууль тогтоомжид заасан бусад.

39 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн нийтлэг эрх, үүрэг

39.1.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

39.1.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 144.1-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн ажиллах орчин, нөхцөл бүрдүүлэх;

39.1.2.нийтийн зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх;

39.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний амжилт, бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах;

39.1.4.хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэх явцад хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд тусламж, дэмжлэг үзүүлэх;

39.1.5.байгууллага өөрчлөн зохион байгуулагдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 39.1.4-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;

39.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчих, ялгаварлах, бэлгийн дарамт үзүүлэхийг үл тэвчих асуудлыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлэх;

39.1.7.хуулийн этгээд нь бараа, ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарласан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг давуу эрхтэйгээр оролцуулах;

39.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

40 дүгээр зүйл.Төрийн бус байгууллагад тавигдах шаардлага, нийтлэг эрх, үүрэг

40.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага нь төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна;

40.1.1.төрийн бус байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, магадлан итгэмжлэлтэй байх;

40.1.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, ажлын байртай, хоёроос доошгүй үндсэн ажилтантай байх.

40.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага бусад хууль тогтоомжид зааснаас гадна дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

40.2.1.холбогдох хууль тогтоомж, төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, бодлого,-хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих;

40.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагаанд хяналт тавих;

40.2.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний, дэд болон салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд оролцох;

40.2.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлаар салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, шийдвэрийг таниулах сургалт, сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах, гэрээгээр гүйцэтгэх;

40.2.5.энэ хуулийн 7.3, 15.3, 17.3, 24.9, 25.1.4-т заасан төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх;

40.2.6.хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулахад оролцох, санал өгөх;

40.2.7.хууль тогтоомжид заасан бусад.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

41 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах салбарын ажилтны нийгмийн баталгаа

41.1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтан Төрийн албаны тухай хуульд зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

41.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах төрийн үйлчилгээний салбарын ажилтанд ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 1 удаагийн мөнгөн урамшуулал олгох;

41.1.2.орон байр барих эсхүл худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламжид хуульд заасны дагуу хамрагдах;

41.1.3.тухайн нутаг дэвсгэрийн онцлог, төвөөс алслагдсан байдлыг харгалзан нэмэгдэл цалин, урамшуулал, бусад дэмжлэг авах;

41.1.4.хуульд заасан бусад баталгаа

41.2.Энэ хуулийн 42.1-т заасан нийгмийн баталгааны хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, шаардлагатай хөрөнгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн жилийн төсөвт тусгана.

42 дугаар зүйл.Гомдол, нэхэмжлэл гаргах

42.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчийг асарч буй хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтанд хүсэлт, шаардлагыг өөрөө, эсхүл хууль ёсны төлөөллөөрөө дамжуулан гаргах эрхтэй.

42.2.Өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл тухайн байгууллагын гаргасан тушаал шийдвэрийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх зөрчигдсөн гэж үзвэл тэдний эрх ашгийг төлөөлсөн байгууллага нь холбогдох шүүхэд гомдол гаргана. Шүүхээр тогтоогдсон бодит хохирлын 10 хувийг тухайн төлөөллийн

байгууллагын гаргасан зардлыг санхүүжүүлэхэд нь зориулж шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлага дээр нэмж төлүүлнэ.

43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

43.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

43.3.Энэ зүйлийн 43.1, 43.2-т заасан этгээдийг энэ хуулийн 7.1.1-д заасан агуулга бүхий, 8-аас доошгүй цагийн албадан сургалтад хамруулна.

43.4.Энэ зүйлийн 43.3-т заасан сургалтыг энэ хуулийн 7.2-т заасан журмын дагуу шаардлага ханган сургалт зохион байгуулах эрх авсан байгууллага нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

43.5.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд гэм хор, хохирол, хор уршиг учирсан бол холбогдох хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

43.6.Энэ хуульд заасан тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах зорилгоор хуурамч бичиг баримт бүрдүүлэх, бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглох ба энэ үйлдэл нотлогдсон тохиолдолд үйлчилгээг зогсоож, учирсан хохирлыг төлүүлнэ.

44 дүгээр зүйл.Хуулийг даган мөрдөх

44.1.Энэ хуулийг 202... оны дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн даган мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “тохирох хэрэглэгдэхүүн” гэснийг “шаардлагатай тохируулга” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.10-т “14.4.10.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшил төлөвшүүлэх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дах хэсгийн “12 дугаар” гэснийг “11 дүгээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.11 дэх заалтын “тохирох хэрэглэгдэхүүн” гэснийг “шаардлагатай тохируулга” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дээд боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.5¹ дахь хэсэг:

“18.5¹. уг зүйлийн 18.1-д заасан элсэлтийн шаардлага, 18.4-т заасан босго оноог хөгжлийн бэрхшээлтэй элсэгчийн бэрхшээлийн хэлбэр, онцлог хэрэгцээг харгалзан ялгаатай тогтоож болно. ялгаатай тогтоож болох”

“18.5². Энэ хуулийн 18.5¹-д дурдсан зохицуулалтад хамрагдах шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй элсэгчийн мэдээллийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэгтгэн хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.8 дахь хэсэг нэмсүгэй:

“38.8.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол хүүхдийн бэрхшээлийн байдлыг харгалзан тэтгэлгийн хэмжээг шүүх нэмэгдүүлэн тогтооно.”

2 дугаар зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “арьсны өнгө” гэсний дараа “хөгжлийн бэрхшээл” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1.3 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1.2 дахь заалтын “тахир дутуу” гэснийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалтыг нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.6-15.1.10 дахь заалт:

“15.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүн, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор холбогдох хуульд заасны дагуу санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэгийг үзүүлэх.”

“15.1.7.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэнийг хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгт хамруулах,

“15.1.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15.1.1-д заасан ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх”

“15.1.9.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх, аж ахуй эрхлэх чиглэлээр сургалт явуулдаг байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх.”

“15.1.10.хөдөлмөрийн харилцаанд анх орж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байранд эшаардлагатай тохируулга хийх, туслах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан 10 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэг удаа олгоно.”

2/15 дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх хэсэг:

“15.3.Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрны шаардлагатай тохируулгын жагсаалтыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

"15.4.ажлын байрны тохируулга хийх, ажлын байрны тохируулгыг үнэлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 144 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 144.9, 144.10 дахь хэсгийг нэмсүгэй:

“144.9.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 100 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д заасан ажлын байрны дадлагажуулагчийг ажиллуулж болно.”

“144.10.Ажил олгогч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрны шаардлагатай тохируулгын жагсаалтыг дотоод журамдаа тусган мөрдөнө.”

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 144 дүгээр зүйлийн 144.1, 144.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“144.1.Ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу шаардлагатай тохируулгаар хангах замаар хөдөлмөр эрхлэх боломжоор хангах үүрэгтэй.”

“144.6.Ажил олгогч энэ хуулийн 144.1-д заасан шаардлагатай тохируулгаар хангахгүйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохыг хориглоно.”

3 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 144 дүгээр зүйлийн 144.4 дэх хэсгийн “асарч байгаа хүний” гэсний дараа “үүсгэн байгуулсан үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн” гэж, 144 дүгээр зүйлийн 144.8 дахь хэсгийн “бүтэн бус цагаар” гэсний дараа “ажлын цагийн уян хатан нөхцөлтэйгээр” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.27, 3.1.28 дахь заалт:

“3.1.27.”боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээг.”

“3.1.28.”туслах бүтээгдэхүүн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 4.1.3-т заасан бүтээгдэхүүнийг.”

2/24 дүгээр зүйлийн 24.6.9 дахь заалт:

“24.6.11.18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмийн зардал”

2 дугаар зүйл. Энэ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.7–г дараах байдлаар өөрчлөн найруулсугай

“24.6.7.удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэг, хөнгөвчлөх болон холголт, цооролтын үеийн эмчилгээ, эм, асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын зардал.”

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6, 40 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсгийн “протез” гэснийг “туслах бүтээгдэхүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 дахь заалтыг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол хэлний тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт:

“4.1.5.”дохионы хэл” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд орох хэлийг.”

2/5 дугаар зүйлийн 5.2¹ дахь хэсэг:

“5.4.Дохионы хэл бол сонсголын бэрхшээлтэй иргэдийн эх хэл мөн бөгөөд дохионы хэлээр нийгмийн бүхий л харилцаанд орох эрхтэй.”

3/21 дүгээр зүйлийн 21.6¹ дахь хэсэг:

“21.6¹.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд Дохионы хэлний хөгжлийн орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллах ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл батална.”

2 дугаар зүйл. Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “”эх хэл дээр” гэсний дараа “болон дохионы хэлээр” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтын “өргөжүүлэх” гэсний дараа “дохионы хэлийг нийтэд түгээх, эзэмшүүлэх” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “бичгийн” гэсний дараа “болон дохионы хэлний” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “монгол хэл” гэсний дараа “дохионы хэл” гэж, 21 дүгээр зүйлийн 21.7.1 дэх заалтын “монгол хэл” гэсний дараа “дохионы хэл” гэж, мөн зүйлийн 21.7.4 дэх заалтын “үгсийн сангйн толь” гэсний дараа “дохионы хэлний үгийн сангийн” гэж, 22 дугаар зүйлийн 22.2.2 дахь заалтын “мэргэжлийн хэлний” гэсний дараа “дохионы хэлний толь бичиг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 19 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 19.1.4, 19.1.5 дахь заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.1.5 дахь заалт:

“19.1.4.хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, түүний хууль ёсны асран хамгаалагч, хувийн туслахыг паралимп, тусгай олимп, дифлимп, тив, дэлхийн тэмцээнд холбогдох журмын дагуу шалгаран оролцоход нь шаардагдах зардлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төсөвт тусгана.”

“19.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 29 дүгээр зүйлд туссан арга хэмжээг хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн 18.4 гэсний дараа “19.1.4” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.12 дахь заалтын “тахир дутуу” гэснийг “хөгжлийн бэрхшээлтэй” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.1.2.”туслах бүтээгдэхүүн” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.3-т заасныг;”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 14.2, 14.3, 14.4, 14.5 дахь хэсгийн “протез, ортопедийн” гэснийг “туслах бүтээгдэхүүний” гэж, 14.4 дэх хэсгийн “протез, ортопедийг” гэснийг “туслах бүтээгдэхүүнийг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.4.3¹ дахь заалт нэмсүгэй:

“22.4.3¹.Залуучуудын хөгжлийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх бүхий л хөтөлбөр, арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг шаардлагатай тохируулгаар хангах замаар тэгш хамруулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.4.20 дахь заалт нэмсүгэй:

“41.4.20. Амьжиргааны доод түвшинээс доогуур орлоготой хөгжлийн бэрхшээлтэй хүний шүүх шинжилгээг хийхэд.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсгийг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг:

“13.6.Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан сургалтын агуулгад хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах, аврах агуулгыг заавал тусгана”

2/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө батлан хэрэгжилтэд хяналт тавина.”

3/30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг:

“30.5.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хувийн туслахын болон дохионы хэлмэрч зэрэг дэмжих үйлчилгээгээр хангагдах эрхээ эдлэх боломжийг заавал бүрдүүлнэ.”

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “ил тод” гэсний дараа “хүртээмжтэй” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “үл харгалзан” гэсний дараа “хүртээмжтэй” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “сайн дурын хэсэг” гэсний дараа “хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах ажилтан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.1.19 дэх заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.19 дэх заалт:

“3.1.19."урьдчилан сэргийлэх" гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.1.7¹ дахь заалт:

“6.1.7¹.байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ болон асран хамгаалагч.”

2/9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт:

“9.1.16.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 22.6-д заасан холбогдох арга хэмжээ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “ерөнхий нэршлийн эм” гэсний дараа “асаргаа сувилгааны хэрэгсэл, ариун цэвэр-эрүүл ахуйн материалыг” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.1.21 дахь хэсэг нэмсүгэй:

“21.1.12¹.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 30 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.5¹, 16.4 дэх хэсэг тус тус нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.1.5¹ дахь хэсэг:

“16.1.5¹. Энэ хуульд заасан бүх төрлийн дэмжлэг болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих сангаас олгох хөнгөлөлттэй зээлд хөгжлийн бэрхшээлтэй үйлдвэрлэл эрхлэгч, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнийг асарч байгаа эх /эцэг/, хууль ёсны асран хамгаалагчийн байгуулсан аж ахуйн нэгжийг хамруулах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;”

2/16 дугаар зүйлийн 16.4 дэх дахь хэсэг:

“16.4. Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5¹-д заасан арга хэмжээнд хамруулахад тавих шаардлага, хөрөнгийн хэмжээг батлах;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.2.4¹ дэх заалт:

“8.2.4¹.хөгжлийн бэрхшээлтэй тамирчинд олгох тусламж”

2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.6 дахь заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“13.5.6.байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хүүхэд;”

3 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “иргэний нийгмийн хамгааллын” гэснийг “хүний эрхийн” гэж, 12.1.2, 12.1.3, 13.5.7 дахь заалтын “16” гэснийг “18” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ